



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 11 дугаар сарын 21

№ 02/85 УАГ-НАГ/2017/03-НА

Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1д заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийх явцад Сайхан-Овоо сумын эмйн эргэлтийн сан нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 3.1.2 дахь /төрийн өмчит үйлдвэрийн газар;/, /6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:/, 6.1, 6.4, Засгийн Газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4.1.1-4.1.17 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.7-дахь /Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;/ заалтуудыг үндэслэн ШААРДАХ НЬ:


1. Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу сар, улирал, хагас бүтэн жилээр оруулах тайлан, мэдээ, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нөхөн байршуулах,
2. Хуулийн хэрэгжилт хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулах.

Албан шаардлагын биелэлтийг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сайхан-Овоо сумын Эмийн эргэлтийн сангийн эрхлэгч /Г.Өлзийсүрэн/, нягтлан бодогч /Г.Бум-Аюуш/ нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup> :

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ

ЭМИЙН ЭРГЭЛИЙН САНГИЙН ЭРХЛЭГЧ  Г.ӨЛЗИЙСҮРЭН

НЯГТЛАН БОДОГЧ

Г.БУМ-АЮУШ



ЗӨВШӨӨРСӨН:

САЙХАН-ОВОО СУМЫН

ЭМЧИЙН ЭРГЭЛИЙН САНГИЙН ЭРХЛЭГЧ

Г.БУМ-АЮУШ

<sup>2</sup> Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүнэ/